# Үзлэгийн тасгууд

- Мэдээгүйжүүлэлтийн тасаг
- Зүрх судасны тасаг
- Шүдний тасаг
- Оношлогооны тасаг
- Дотоод шүүрлийн эрхтэн тогтолцооны тасаг
- Үргүйдлийн эмчилгээний тасаг
- Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны тасаг
- Ерөнхий мэс заслын тасаг
- Мэдрэлийн эрхтэн тогтолцооны тасаг
- Эх барих эмэгтэйчүүдийн тасаг
- Эмгэг судлалын тасаг
- Хүүхдийн мэс заслын тасаг
- Хүүхдийн тасаг
- Сэтгэцийн эрүүл мэндийн тасаг
- Амьсгалын эрхтэн тогтолцооны тасаг
- Дүрс оношлогооны тасаг
- Урологийн тасаг

## Байршил




566 Nonhyon-ro, Gangnam-gu, Seoul, Korea

## Холбоо барих

- +82 10 8866 2268 (Англи хэл)
- +82 10 2810 8576 (Хятад хэл)
- +82 10 5759 5003 (Орос хэл)
- +82 10 2813 3534 (Монгол хэл)
- Имэйл хаяг – chamcic@chamc.co.kr

## Олон улсын эмчилгээний төв

+82 2 3468 2632 / 3404

## Үйлчлүүлэх цагийн танилцуулга

- 9 цаг (үдээс өмнө) ~ 5 цаг (үдээс хойш) — Ажлын өдрүүдэд
- 9 цаг (үдээс өмнө) ~ 12 цаг (үдээс хойш) — Бямба гариг
- 12:30 цаг (үдээс хойш) ~ 1:30 цаг (үдээс хойш) — Өдрийн цайны цаг

## Цахим хуудас

https://gangnam.chamc.co.kr

YouTube

Facebook

Instagram

# CHA GANGNAM MEDICAL CENTER

CHA UNIVERSITY
GANGNAM MEDICAL CENTER


CHA Gangnam Medical Center Main Building

# Ча Кангнам эрүүл мэндийн төв, Ча их сургуулийн тухай

ЧА Эмнэлгийн Групп нь 1960 онд ЧА эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлэж байлаа. Түүнээс хойш тасралтгүй дэвшин хөгжсөөр эх барих эмэгтэйчүүд, үргүйдлийн эмчилгээ, дотор, ерөнхий мэс засал, хүүхдийн тасаг болон бусад тасгууд нь чанартай эмчилгээ үйлчилгээ үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

1986 онд ЧА Эмнэлгийн Групп нь БНСУ-д анх удаа үр шилжүүлэн суулгах(биеийн гадна орчинд үр тогтоон умайд шилжүүлэн суулгах IVF) ажилбар, тухайн жилдээ дэлхийн хэмжээнд анх удаа эр бэлгийн эс болон өндгөн эсийг (биеэс гадна орчинд үр тогтоолгүйгээр) хэвлийн дурангаар дамжуулан үрийн сувагт суулгаж үр тогтоох (GIFT) ажилбарыг амжилттай хийв. 1998 онд анх өндгөн эсийг талст үүсгэхгүйгээр хөлдөөх арга, өндгөн эсийг хөлдөөх стандарт технологийг боловсруулж, дэлхийн нөхөн үржихүйн анагаах ухааны үргүйдлийг эмчлэх эмнэлзүйн болон технологийн салбарт тэргүүлэх болов.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбар дахь 60 жилийн туршлагадаа суурилан Ча Кангнам эрүүл мэндийн төв нь үргүйдлийг эмчлэх эмчилгээнээс эхлэн төрөх хүртэлх аюулгүй найдвартай, үр дүнтэй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг нарийн мэргэжлийн тэргүүлэх эмнэлэг юм.




CHA Gangnam Fertility Center

## Ча Кангнам эрүүл мэндийн төв

**Ча Кангнам эрүүл мэндийн төв** нь эмэгтэйчүүдийн өвчин эмгэгийг оношлох болон эмчлэх, хамгийн бага зүсэлттэй мэс ажилбарын чиглэлээр мэргэшсэн төв юм. Манай эмнэлгийн эмчилгээний болон мэс заслын нарийн мэргэжлийн эмч нар хамтарсан оношлогоо болон мэс заслын арга барилаа ашиглан хүнлэг энэрэнгүй, тухайн хүнд тохирсон эмнэлгийн тусламж үйлчилгээг нэг цэгт үзүүлж байна.

- **Умайн хүзүүний хорт хавдар**
- **Умайн салст бүрхэвч буюу эндометрийн хорт хавдар**
- **Өндгөвчний хорт хавдар**
- **Хэвлийн гялтангийн хорт хавдар**
- **Хөхний хорт хавдар**
- **Бамбай булчирхайн хорт хавдар**
- **Фаллопиевын гуурс**
- **Умайн булчингийн хоргүй хавдар буюу миома**
- **Да Винчи робот мэс засал**
- **Өндгөвчний уйланхайн эмчилгээ**
- **Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин**

## Үргүйдлийн төв

**Ча Кангнам үргүйдлийн төв** нь жилд 5000 гаруй үр шилжүүлэн суулгах ажилбар хийдэг бөгөөд үргүйдлийн эмчилгээний амжилтын түвшинагөөрөө улсдаа тэргүүлэх байрыг эзлэж байна.

- **Үргүйдлийн зөвлөгөө**
- **IVF**(Биеийн гадна орчинд үр тогтоон умайд шилжүүлэн суулгах)
- **IVM**(Өндгөн эсийг биеийн гадна орчинд өсгөвөрлөх)
- **Өндгөн эс боловсрон гадагшлах үйл явц саатах**
- **Өндгөн эсийн**(бүрэн боловсроогүй) **сан буюу банк**
- **Эр бэлгийн эс буюу спермийн сан буюу банк**
- **Үр хөврөл умайн хананд бэхлэгдэхийн өмнө хийгдэх генетикийн шинжилгээ PGT-A, PGT-M, PGT-SR**
- **Үргүйдлийн шинжилгээнд өндгөвчний нөөц тодорхойлох шинжилгээ, даавврын шинжилгээ, үрийн шингэний шинжилгээ, хуухнагны эхо буюу хэт авиан шинжилгээ багтана.**

**Үргүйдлийн шинжилгээ өгөх болон эмчилгээ хийлгэхдээ сарын тэмдгийн мөчлөгийн 2 дахь өдрөө ирэхийг зөвлөж байна.**


CHA Gangnam Women's Medical Center & Medical Hotel

## Амаржих төв

**Каннам Ча эмнэлгийн амаржих төв** нь хамгийн нарийн эмчилгээ сувилгаа шаардагдсан эрүүл мэндийн хувьд асуудалтай нөхцөлд байгаа өндөр эрсдэлтэй жирэмсэн эхчүүдийг хүлээж авдаг мэргэшсэн төв юм.

- **Өндөр эрсдэл бүхий жирэмслэлт**
- **Кесар хагалгааны дараа үтрээгээр төрөх төрөлт**
- **Төрөхийн өмнөх тусламж үйлчилгээ**
- **Эх барихын эрчимт эмчилгээний тасаг**
- **Амаржсны дараах сувилалын газар** (2 долоо хоногийн багц хөтөлбөр)

**Каннам Ча эмнэлгийн амаржих төв** нь ургийн нөхцөл байдал өндөр эрсдэлтэй байгаа гэж таамаглагдсан эсвэл батлагдсан жирэмсэн эхчүүдэд цогц тусламж үйлчилгээг үзүүлж байна.

- **NICU**(Нярайн эрчимт эмчилгээний тасаг)
- **Хүйн цусыг хадгалах**
- **Дутуу төрсөн нярайн нарийн мэргэжлийн эмчилгээ үйлчилгээ**

## Хүүхдийн төв

**Манай хүүхдийн нэгдсэн эмчилгээ үйлчилгээнд** жил бүр хийгдэх эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, төлөвлөгөөт вакцинжуулалт, сонсгол шалгах, жингийн хяналт зэрэг багтдаг.

- **Хүүхдийн зүрхний эмгэг**
- **Амьсгалын замын эмгэг**
- **Мэдрэлийн эрхтэн тогтолцооны эмгэг**
- **Хүүхдийн чих, хамар, хоолой**
- **Шээсний замын халдварz**
- **Арьсны халдвар болон харшил**
- **Бронхит, бронхиолит**
- **Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ болон вакцинжуулалт**